



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г Амарын гудамж, Сойлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.09.01 № 1576  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР  
ДЭВШИХ ИРГЭН  
Ц.ДАВААДОРЖ ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвших иргэн Цэнддаваагийн Даваадоржийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлэн хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа 2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Иргэн Цэнддаваагийн Даваадоржийн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн сонгуулийн

мөрийн хөтөлбөр, түүнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Цэнддаваагийн Даваадоржийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (3 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Нийслэлийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 3 хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НОМИНБААТАР



# **“ШИНЭ УЛААНБААТАР”**

**2020 ОНЫ НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД  
БИЕ ДААН НЭР ДЭВШИХ  
ЦЭНДДАВАА ОВОГТОЙ ДАВААДОРЖИЙН  
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020 он

---

*“ШИНЭ УЛААНБААТАР” уриатай,  
Нийслэлийн нийгэм, эдийн засаг, байгаль орчин, засаглалын өнөөгийн эрэлт  
хэрэгцээнд тулгуурласан мөрийн хөтөлбөрөө танилцуулж байна.*

---

## **1. Тэгш хүртээмжтэй, Түргэн шуурхай нийгмийн үйлчилгээг бүрдүүлнэ**

- 1.1. Авилгаас ангид, нийгмийн бүх хүрээний оролцоог хангасан, мэргэшсэн тогтвортой, засаглалыг төлөвшүүлнэ.
- 1.2. Олон нийтийн оролцоотой шийдвэр гаргах, хяналт тавих тогтолцоо бий болгоно.
- 1.3. Хотын төрийн албаны үйлчилгээг хүртээмжтэй, хурдан шуурхай болгоно.
- 1.4. Эрүүл мэндийн сургалт мэдээллийн тогтолцоог сайжруулж, нийслэл хотод өрхийн эмнэлэг, төрөх, хүүхдийн эмнэлэгийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийн ололтыг нэвтрүүлж, ухаалаг, хүртээмжтэй түргэн шуурхай болгон, эмнэлэгийн үйлчилгээг сайжруулна.
- 1.5. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүрэлцээг нэмэгдүүлэх, боловсролын чанарыг жишиг стандартад нийцүүлнэ.
- 1.6. Нийтийн тээврийн сүлжээний ашиглалт, багтаамж, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохион байгуулалт менежментийн арга хэмжээг мэргэжлийн холбоодын оролцоотойгоор явч хэрэгжүүлнэ.

## **2. Хүрээлэн буй орчны бохирдлыг арилгаж, эрүүл цэвэр орчныг бүрдүүлнэ**

- 2.1. Хөрс, ус, агаар орчны бохирдлыг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 2.2. Хотын орчны бүсэд ногоон байгууламжийг нэмэгдүүлж, тохижилтыг сайжруулна. Энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжүүдийг хөгжүүлнэ.
- 2.3. Гэмт хэргийн гаралт, зам тээврийн ослыг бууруулах зорилгоор орчны аюулгүй нөхцлийг хангана.
- 2.4. Олон нийтийн амралт, чөлөөт цаг өнгөрөөх зориулалттай талбай, цогцолборыг тохижуулна.
- 2.5. Хуи хаягдалын менежмент улам боловсронгуй болгох замаар дахин боловсруулах үйлдвэрүүдийг бодлогоор дэмжин ажиллана.
- 2.6. Аж ахуйн нэгжүүдэд татварын дэмжлэг үзүүлэх замаар саарал усыг ашиглах технологийн хэрэглээг нэмэгдүүлнэ.

## **3. Ажилгүйдлийн түвшин бууруулна.**

- 3.1. Хотыг эрүүл аюулгүй хүнсээр хангах үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.



3.2. Хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, мэдээллийн санг боловсронгуй болгож, хөдөлмөрийн зах зээлд суурлисан хөдөлмөр зуучлалыг хүртээмжтэй болгож, ажил эрхлэлтийг дэмжинэ.

3.3. Орон нутгийн онцлогт тохируулж аялал жуулчлалын салбарыг өргөжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.

3.4. Хотын орчны бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг шаталсан татварын бодлогоор дэмжинэ.

#### 4. Нийслэлийн төвлөрлийг бууруулна.

4.1. Нийслэлийн дагуул хот, тосгодуудыг хөгжүүлэх бодлогыг дэмжих замаар нийслэл хотын хүн ам, дэд бүтцийн төвлөрлийг үе шаттайгаар бууруулах бодлого хэрэгжүүлнэ.

4.2. Хотын хүрээлэн буй орчны даацад тулгуулан шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хот төлөвлөлтийг улам сайжруулна.

4.3. Дундаас доош орлоготой бүлгийнхэнд чиглэсэн орон сууцны нийлүүлэлт бий болгох замаар гэр хорооллыг орон сууцжуулах бодлого баримтална.

4.4. Хотын бүсчлэлээр хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөнийг жигд байлгахад чиглэгдсэн урамшуулал, шаталсан татварын бодлого баримтална.

4.5. Хотын төвлөрлийг сааруулах авто замын оновчтой бүтцийг илүү оновчтойгоор хөгжүүлнэ.

#### 5. Дэд бүтэц, орон сууцны асуудлыг шийдвэрлэх

5.1 Дэд бүтцийн салбарт шаардлагатай холбогдох олон улсын стандартыг нэвтрүүлнэ.

5.2 Байгаль, хүн, эдийн засагт ээлтэй материалыг хотын бүтээн байгуулалтад ашиглах бодлогыг дэмжинэ.

5.2. Эрчим хүчний дамжуулах системийн алдагдлыг бууруулах, хэмнэлттэй ашиглах чиглэлээр төрийн бодлогыг оновчтой хэрэгжүүлнэ.

5.3. Хот төлөвлөлтөд нийцсэн газар зохион байгуулалтыг оновчтой болгож менежментийг боловсронгуй болгоно.

5.4. Бороо, цас үерийн усыг зайлуулах системийг нэвтрүүлнэ.

Мэдээллийг бэлтгэсэн \_\_\_\_\_-ыг төлөөлж

овог нэр

гарын үсэг

Цэцэгдэвчигийн Давраг - ыг

Төлөөлж

/нэр дэвшигчийн нэр/

овог нэр

гарын үсэг

2020 оны 7 сарын 24 өдөр

---оОо---

